
ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

НЭГ. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Тахько (ХК) компани Монгол улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1992 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 32 дугаар тогтоолоор хувьчлагдах шийдвэр гарч, Тахько хувьцаат компани (100 хувь хувийн өмчид шилжсэн) байгуулагдсан үеэс одоог хүртэл тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Тус компани 1992 онд буюу хувьчлагдах үеийн эхлэлтийн балансаар 345,567.5 мянган төгрөгийн өөрийн хөрөнгөтэй, нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 592,830 ширхэг энгийн хувьцаатай байсан бол 2016 оны жилийн эцсийн байдлаар 14,487,147.5 мянган төгрөгийн хөрөнгөтэй, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нэг бүр нь 168 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийтэд зарласан чөлөөтэй арилжаалагдах 1,189,983 ширхэг энгийн хувьцаатай нээлттэй хувьцаат компани болсон юм.

Тахько (ХК) компани нь хувьчлагдахаас өмнө улсын үйлдвэр байхдаа оёдлын үйлдвэрлэлийн шугам, тоног төхөөрөмж шинэчлэхээр авсан банкны урт хугацаатай 92,772.5 мянган төгрөг, 649.9 мянган ам.доллар, 29,134.8 мянган йений зээлтэйгээр хувьчлагдсан бөгөөд эдгээр бүх зээлийг хүүгийн хамт 1992-1999 онуудад өөрийн орлогоор бүрэн төлж барагдуулснаар банкны зээлийн өр төлбөргүй аж ахуйн нэгж болсон.

Тахько (ХК) компани үүсэн байгуулагдсанаас хойш эрхэлж буй үйл ажиллагаа, компанийн өмнө тавигдсан зорилтыг амжилттай хэрэгжүүлж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг жил бүр тогтоосон хугацаанд зарлан хуралдуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулж хэвшсэний дээр, байгуулагдсаны дараагийн жил (1992-2016 он)-ээс одоог хүртэл компанийн хувьцаа эзэмшигчдэд нийтдээ 885,750.0 мянган төгрөгийн ногдол ашиг хуваарилсан байна.

Тахько (ХК) компани нь одоогийн байдлаар үл хөдлөх хөрөнгийн түрээс, үйлчилгээ, гадаад дотоод худалдаа, хөрөнгө оруулалтын зэрэг үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр ажиллаж байна.

ХОЁР. 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

Компанийн засаглал

Тахько (ХК) компанийн захиргаа 2016 онд (гүйцэтгэх удирдлага, зохион байгуулалтын нэгжийн албадууд) Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, Компанийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулж ажилласан.

Компанийн захиргаа 2015 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2015 оны санхүүгийн тайланд аудит хийлгэсэн тухай PWC аудит компанийн дүгнэлт, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ, ногдол ашиг хуваарилах, компанийн 2016 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулах зэрэг асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 28 заалт бүхий 9 тогтоол шийдвэр гаргуулан тэдгээрийн биелэлтийг бүрэн хэрэгжүүлж ажилласан.

Компанийн захиргаа Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаа, төрийн зохицуулах байгууллагаас баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн зарлаж, хүчин төгөлдөр саналын эрхийн 86.09 хувийн ирцтэйгээр хуралдуулж, хурлаар хэлэлцсэн асуудлыг хуралд оролцогчдын ердийн олонх (63.12-63.68 хувийн)-ийн саналын эрхээр шийдвэрлүүлсэн болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр (ТУЗ-ийн 2016.02.03-ны №01 тогтоол)-ийн дагуу компанийн 2015 оны цэвэр ашгаас 1,189,983 ширхэг энгийн хувьцаанд хуваарилсан 128,518.2 мянган төгрөгийн ногдол ашгаас хувь хүний орлогын албан татварт 12,851.8 мянган төгрөг суутган харъяалах татварын байгууллагад шилжүүлэн тайлагнаж, 115,666.3 мянган төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв компаниар зуучлуулан 623 хувьцаа эзэмшигчийн төвлөрсөн хадгаламж дахь дансанд 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр байршуулан олгож, хууль, журам, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тогтоосон хугацаанд тайлагнаж, олон нийтэд болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлсэн болно.

Монголын хөрөнгийн биржтэй 2016.05.24-нд Үнэт цаасны бүртгэлийн гэрээ, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй 2016.03.10-нд Үнэт цаасны хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээг тус тус шинэчлэн байгуулж, эдгээр гэрээгээр хүлээсэн 41 үүргийг хэрэгжүүлж, Хөрөнгийн биржээс тогтоосон шалгуур үзүүлэлтийг биелүүлж ажилласан.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443 дугаар тогтоол, Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн шинэ журмын дагуу санхүүгийн ба санхүүгийн бус тайлан, хугацаат ба тухай бүр мэдээлэх мэдээллийг зохих байгууллагуудад тогтоосон хугацаанд мэдээлж, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржийн шинэ журмаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлж ажилласан.

Компанийн гүйцэтгэх удирдлагын ажилтнууд Санхүүгийн зохицуулах хороо, Компанийн засаглалын үндэсний төв, холбогдох бусад байгууллагаас зохион байгуулсан компанийн засаглалтай холбогдолтой хурал, семинар, зөвлөлгөөн, сургалт, форумд оролцож, судалгаа, мэдээлэл авч компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажилласан.

Санхүүгийн зохицуулах хороо, Компанийн засаглалын хөгжлийн төв болон бусад байгууллагаас хамтран зохион байгуулсан жилийн тайлан шалгаруулах ARAM төсөлд хамрагдаж, компанийн жилийн тайланг олон улсын стандарт шаардлагын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын захидал, Гүйцэтгэх захирлын мэндчилгээ, компанийн товч түүх, бүтэц, алба нэгжийн чиг үүрэг, стратеги, бизнесийн мэдээлэл, компанийн засаглал, нийгмийн хариуцлага, дотоод аудиторын тайлан, санхүүгийн гол гол үзүүлэлт, хараат бус аудиторын дүгнэлт, санхүүгийн байдал зэрэг агуулгаар бичиж, ном болгон хэвлүүлж, шилдэг тайлан шалгаруулах үндэсний анхдугаар уралдаанд оролцож, олон улсын стандартыг мөрдлөг болгон ажиллаж, төслийг амжилттай хэрэгжүүлсэн байгууллагаар шалгарсан.

Компанийн веб хуудасны мэдээ мэдээллийг тухай бүрт нь шинэчилж, Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл, Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, компанийн бусад мэдээллийг

мэдээлж, хувьцаа эзэмшигч болон олон нийтийг мэдээллээр хангах үүргийг хэрэгжүүлсэн.

Компанийн бүтэц, зохион байгуулалт

Тайлангийн хугацаанд компани 2016 онд 31 орон тоо бүхий (Гүйцэтгэх захирлын 2016.01.03-ны 01 тоот тушаалаар баталсан) Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, захиргаа болон техник үйлчилгээний алба, анкор төв гэсэн бүтэцтэй ажиллаж, байнгын ажлын байрны 27 ажиллагсадтай ажилласан.

Нийт ажилтнуудад өмнөх жилд шинэчилж мөрдсөн үндсэн цалинг нэмэгдсэн хэмжээгээр нь хэвээр олгож, Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан үүрэг, хариуцсан ажлын биелэлт, үр дүнг үндэслэн үндсэн цалингийн 40 хүртэл хувийн цалингийн урамшууллыг улирал тутамд олгосон. 2016 онд нийт ажилтнуудад, удирдлага, ТУЗ-ийн гишүүдийн цалин, улирал, жилийн эцсийн шагнал, урамшуулалд нийтдээ 1,039,600.5 мянган төгрөгийг олгосон бөгөөд энэ нь тайлант жилийн нийт зардлын 37.7 хувийг эзэлж байгаа.

Компанийн 2016 оны зохион байгуулалтын баримт бичгийг зааврын дагуу цэгцлэн архивын 36 нэгж үүсгэн компанийн архивт бүртгэн авч, давхардсан тоогоор 25 удаа 63 баримтын үйлчилгээ үзүүлж, ахмад настан, иргэдийн хүсэлтээр ажилласан хугацаа, тушаалын хуулбар, цалингийн тодорхойлолт, лавлагаа 11 удаа гаргаж өгсөн байна.

Ажилтнуудын компанид ажилласан хугацааг зөв тооцох зорилгоор Нийгмийн даатгалын болон ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулиар орсон өөрчлөлтийн дагуу ажилтнуудын нийт ба компанид ажилласан хугацааг тодорхойлох огноо, нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан болон компанид ажилласан хугацааны тодорхойлолтыг хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр, нөхөн тооцсон баталгаажуулалтын хуудас, архивын баримт бичгийг үндэслэн шинэчилж, Гүйцэтгэх захирлын тушаал (2016.01.15-ны № 02)-аар батлан мөрдөж байна.

Компанийн тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн аудитын байгууллага болох Прайсуотерхаускуперс аудит ХХК-тай аудитын гэрээбайгуулан ажиллаж, 2015 оны жилийн санхүүгийн тайланд олон улсын түвшингийн аудитын баталгаажуулалт хийлгэж, дүгнэлт тайланг хүлээн авч Төлөөлөн удирдах зөвлөл болон 2016 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

2016 оны санхүүгийн тайланд аудит хийх компаниар Прайсуотерхаускуперс аудит ХХК-ийг дахин сонгох шийдвэр (Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 2016.06.28-ны 11 дүгээр тогтоол) гаргуулж, Аудитын гэрээг 2016.06.30-ны өдөр байгуулсан.

Аудитын энэ компанийг аудитороор үргэлжлүүлэн сонгож ажиллуулснаар тус аудитын компаниас зохион байгуулсан “ННБОУС-17 Түрээс, шинэ стандарт болох СТОУС-16, СТОУС-ын өөрчлөлтүүд”, “Орлого хүлээн зөвшөөрөхтэй холбоотой НББОУС-11 Барилгын гэрээ, НББОУС-18 Орлого, НББОУС-20 Засгийн газрын тусламж, шинэ стандарт болох СТОУС-15”, “Үндсэн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгүүдийн дахин үнэлгээ, түүний татварын нөлөөллүүд”, “Мөнгөн гүйлгээний тайлан /шууд бус аргаар/- НББОУС-7” сэдэвт сургалтуудад нягтлан бодогч нарыг суралцуулж, СТОУС, НББОУС-ыг нэвтрүүлэх талаар зөвлөгөө авч, 2016 оны (урьдчилсан тайлан гаргаж, 3 дугаар улирлын байдлаар явцын аудит хийлгэж) санхүүгийн тайланг “А” форматаар болон санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу гаргаж, хараат бус хөндлөнгийн аудит хийлгэсэн.

Гүйцэтгэх удирдлагыг шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх журам, Эрх бүхий албан тушаалтны ажлыг дүгнэх журам, Компанийн төлөвлөгөө, төсөл боловсруулах журам, Нууцын журам, Ажилтны ёс зүйн дүрмийн төслүүдийг тус тус боловсруулан баталж, 2017 оноос мөрдөж эхлэхээр бэлтгэсэн.

Компанийн Нягтлан бодох бүртгэлийн⁴ бодлогын баримт бичгийн шинэчлэлтэй холбогдуулан Интерактив Ай Би Ай ХХК-тай хамтран санхүүгийн программд зохих өөрчлөлт оруулж, орлого, зардлын шинэ дансуудыг нээж, бүртгэл хөтлөлтийг хийж, үндсэн үйл ажиллагааны орлоготой холбогдож гарсан засвар үйлчилгээ, ашиглалт,

цалин гэх мэт зардлуудыг борлуулсан бүтээгдэхүүний өртөг дансанд төвлөрүүлэн бүртгэдэг болсон.

Компанийн танилцуулга, Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлын тушаалар баталсан хүчин төгөлдөр мөрдөж буй дүрэм, журам, заавар, санамж бүхий гарын авлагыг эрх бүхий албан тушаалтан болон шинээр ажилд орох ажилтнуудад зориулсан байдлаар хийж, ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна.

Компанийн өмч хөрөнгийг эрсдэлээс хамгаалах зорилгоор Монгол даатгал компанитай байгуулсан даатгалын гэрээнүүдийн дагуу 2016 онд бүх төрлийн даатгал (үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын зэрэг)-ын хураамжинд 21,057.5 мянган төгрөг төлсөн байна. Даатгалын хугацаанд гуравдагч этгээдийн санамсаргүй үйлдлийн эвдэрсэн МА-II барилгын 2 дугаар давхрын цонхнуудын эвдрэлийг засварлахад, гарах 730,000, Гүнт дэх зуслангийн байранд гэмт этгээд халдсаны улмаас хамгаалалтын төмөр хаалтыг шинэчлэн сольж хийх зардалд нийт 920.0 мянган төгрөгийн даатгалын нөхөн төлбөрийг тус тус авсан.

Компанийн барилга (МА-I, МА-II, МА-III, U-I, U-II, U-III)-уудын 1970-д оны БНУУ-д хийгдсэн архитекторын бүх зургуудыг, компанийн МА-I, МА-II, МА-III, U-I барилгын барилга ба түүний инженерийн шугам сүлжээ (барилга архитектур "БА", халаалт салхивч "ХС", цэвэр бохир ус "ЦБУ", цахилгаан "ЦХ", холбоо дохиолол "ХД" -ын хэсгүүд)-ний гүйцэтгэлийн зургуудыг компьютерын JPG файл болгох ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, актаар хүлээн авсан.

Хүний нөөц, нийгмийн асуудал

Хүний нөөцийн үйл ажиллагааг байгууллагын хөгжил болон хүний хөгжилтэй уялдуулан холбож, байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, ажилтан сонгох, ажилд дадлагажуулах, мэргэжил, мэдлэг боловсролыг нь хөгжүүлэхэд анхааран ажилласан болно.

Компани захиргаа тайлангийн хугацаанд 27 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, тэдгээр ажилтнууд хууль тогтоомжид зааснаар давхардсан тоогоор 6,344 өдөр

ажиллахаас 5,699 өдөр ажиллаж, 531 өдрийн ээлжийн амралтыг биеэр эдлүүлж, Хөдөлмөрийн дотоод журамд заасан үндэслэлээр 15 ажилтанд давхардсан тоогоор 64 өдрийн захиргааны чөлөө олгож, 6 ажилтан хөдөлмөрийн чадвар түр алдсан тул 88 өдрийн ажлаас чөлөөгдсөн байна.

Хүний нөөцийг бүрдүүлэх, ажилтнуудын мэргэшил, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 6,552.0 мянган төгрөгийн зардлаар АРАМ төслийн хүрээнд явагдсан компанийн төлөөлөн удирдах зөвлөл, засаглал, тогтвортой байдал, эрсдэлийн удирдлага, санхүүгийн ба санхүүгийн бус тайлагналын сургалтуудадэрх бүхий 14 албан тушаалтныг, мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн эрх сунгах болон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын чиглэлээр нягтлан бодогч нарыг, цахилгаанчдын аюулгүй ажиллагааны групп сунгах, цахилгаанчин, сантехникийн засварчдын мэргэжил дээшлүүлэх сургалтад цахилгаанчин 4, сантехникийн засварчин 4 хүнийг тус тус сургасан.

Оффисын ажилтнуудын эрхэлсэн ажлын болон эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, боловсруулж байгаа асуудлын чанарыг сайжруулах, хууль эрх зүйн үндэслэл, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөхөд өдөр тутмын туслалцаа, зөвлөмжөөр хангаж, тэднийг хөгжүүлэхэд анхаарч ажилласан.

Ажилтнуудын ерөнхий мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, цаг үеийн мэдээллээр хангах зорилгоор сард 2 удаа нийтийн сонсгол, мэдээллийн өдөр бий болгож, тайлангийн хугацаанд хууль тогтоомж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд, эмийн зохистой хэрэглээ, зөв зохистой хооллолт, даатгал, банкны үйл ажиллагаа болон компанийн төлөвлөгөөт ажлын явц, хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт, бусад дотоод асуудлаар 16 удаа сонсгол, мэдээлэл хийж, хэвшүүлж байна.

Ажилтнуудын ажлын цаг ашиглалт, захиргааны чөлөө олголт, Хөдөлмөрийн дотоод журмаар хүлээсэн үүргийн биелэлт болон алба, ажилтнуудын ажлын тайланг бичүүлж, зохих түвшний хамт олны хурлаар сонсож, ажилтан бүрт дүгнэлт, зөвлөлгөө өгч, ажлын хариуцлага, хөдөлмөрийн сахилгыг бэхжүүлэхэд өдөр тутам хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч ажиллаж байна.

2016 онд Хөдөлмөрийн дотоод журам зөрчиж, ажлын байраа дур мэдэн орхиж согтууруулах ундаа хэрэглэсэн, ажлын бус цагаар согтууруулах ундаа хэрэглэсний дараа албаны тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил гаргасан 2 ажилтанд Хөдөлмөрийн дотоод журамд зааснаар сануулах, үндсэн цалинг 3 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэлийг Гүйцэтгэх захирлын тушаалаар ногдуулсан.

Ажилтнуудыг эрүүл мэндийг хамгаалах зорилгоор оношлогооны Сөүл сонгдо эмнэлэгт компанийн зардлаар 5,200.0 мянган төгрөгийн үзлэг оношлогоонд хамруулсан.

Компанийн ажиллагсдын алжаал тайлах амралтыг Дэлхийн аялал компанитай гэрээ байгуулж, нийт ажилтнуудыг Улаанбаатар-Улаан-үд-Байгал далай-Улаан-Үд-Улаанбаатар маршрутаар 4 өдөр 3 шөнийн аялал хийлгэж зохион байгуулсан.

Компанийн хөдөлмөрийн дотоод журмын заалтыг үндэслэн гэр бүлд нь шинээр хүүхэд төрсөн, эрүүл мэнд болон бусад шалтгаанаар гачигдал тохиолдсон тус компанийн 7 ажилтанд 34,833.3 мянган төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн.

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулиар хүлээсэн үүргийн дагуу оёдлын артел, фабрик, оёдлын үйлдвэрийн нэгдэл, компанид ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан 310 ахмадуудыг Монголын ахмадын өдрийг тохиолдуулан Туушин зочид буудлын ресторанд хүлээн авч 21,365.4 мянган төгрөгийн, өндөр настай 19 ахмад ажилтанд цагаан сарын баяраар 855.0 мянган төгрөгийн хүндэтгэл тус тус үзүүлсэн.

Оёдлын үйлдвэр, компанид ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан Хөдөлмөрийн баатар Л.Дашням, Б.Дугуйцагаан, гавъяат ажилтан Д.Даваа нарт 1,600.0, гачигдал тохиолдсон ахмад настан Б.Намжилсүрэнгийн ар гэрт 166.7, Ж.Баавай, Ц.Цэрэнбадам нарт тус бүр 500.0, Б.Должинсүрэнд 1,000.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.

Компанийн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монкорд ХЗХ-той хамтран бага орлоготой өрхүүдийн хувиараа эрхэлж буй бизнесийг дэмжиж тэдний хийж байгаа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой хамтран бага орлоготой зээлдэгчдийн хүүхдүүдийг

баярлуулах арга хэмжээ, Мөрөөдлийн солонго ТББ-тай хамтран амьдралын гачигдалтай хүүхдүүдийг оролцуулсан аз жаргалтай гэр бүлийн өдөрлөг, Японд сургууль төгсөгчдийн Jugato нийгэмлэгтэй хамтран оюутан залууст зориулсан боловсрол мэдлэгийг дээшлүүлэх уулзалт зэрэг нийгэмд чиглэсэн 14 арга хэмжээнүүдийг үнэ төлбөргүй буюу 50 хувийн хөнгөлөлтэйгээр зохион байгуулсан.

Хүрээлэн буй орчинг сайжруулах, хүчилтөрөгчийн эх үүсвэр нэмэгдүүлэх зорилгоор компанийн Гүнт амралтын хашаанд тарьсан 150 ширхэг хайлаас мод, нохойн хошуу модыг арчилж, ургалтыг нэмэгдүүлэх ажлыг хийсэн болно.

ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ

Компанийн орлого нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр

Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор бүх төрлийн хог хаягдал, нүүрснээс шингэн түлш болон цахилгаан гаргаж авах төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг үргэлжлүүлэн хийж байна.

Үйлдвэр байгуулах газрын асуудал (Дархан-Уул аймгийн Дархан суманд 19.4 га газрыг компанийн нэр дээр эзэмших Засаг даргын захирамж гаргуулж, газар эзэмших гэрээг 15 жилээр байгуулсан)-ыг шийдвэрлүүлсэн.

Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан Дарханы хөгжил Олон улсын эдийн засгийн форумд оролцож, үйлдвэр байгуулах төслийн тухай олон улсын оролцогч болон нутгийн иргэдэд танилцуулж илтгэл тавьсан.

Байгаль орчин ногоон хөгжлийн яамнаас зөвшөөрөл авч, төсөл хэрэгжүүлэх байгаль орчны нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллага (Эко натур)-аар 10,454.5 мянган төгрөгөөр хийлгүүлж, 2015 онд санхүүжигдээгүй гэрээт ажлын үлдэгдэл хөлс 5,469.0 мянган төгрөгийг төлбөрийг төлсөн байна.

Хөрөнгө оруулагч нарт шаардлагатай Үйлдвэрийн технологийн үндэслэлийг дэлхийд нэр хүндтэй Ricardo-AEA Ltd компаниар 17,042.9 мянган төгрөгөөр, зах зээлийн судалгааг Хорайзон партнерс ХХК-иар 18,000.0 мянган төгрөгөөр, хаягдал

тосоор эмүльсэн түлш үйлдвэрлэх төслийн зах зээлийн судалгааг Эм Ай Си Жи ХХК-иар 20,000.0 мянган төгрөгөөр тус тус хийлгүүлсэн.

Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэр дэх хог хаягдал цуглуулах менежментийн өнөөгийн нөхцөл байдал, хог хаягдал цуглуулах дэвшилтэд менежментийг нэвтрүүлэх, сайжруулах арга зүйг боловсруулах, хог хаягдлын бүтцийн талаарх нарийвчилсан судалгааг Олон улсын зах зээл инноваци судлалын хүрээлэн ТББ-аар 26,300.0 мянган төгрөгөөр хийлгүүлсэн.

Дархан-Уул аймгийн үйлдвэрийн район дахь эзэмшил газрын улаан шугамыг газар дээр байршуулах ажлыг 1,593.6 мянган төгрөгөөр хийлгүүлж, газрын төлбөрт 5,308.4 мянган төгрөг төлсөн.

Бүх төрлийн хог хаягдал, хүрэн нүүрсийг байгаль орчинд ээлтэй аргаар боловсруулах, дизель түлш цахилгаан үйлдвэрлэх төслийг үйлчлүүлэгч хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Дархан-Уул аймгийн Засаг дарга Үйлчлүүлэгч нарын хооронд хийх санамж бичиг болон төслийг санхүүжилтээр хэрэгжүүлэх ерөнхий бүтэц, ажлын төлөвлөгөө боловсруулах ажлыг Эм Ди Эс энд ХААН Лекс ХХН-аар 10,000.0 мянган төгрөгөөр хийлгэсэн.

Гадаад (Япон улс)-д 2 удаа томилолтоор ажиллаж, Японы GGI trust компанитай үйлдвэр байгуулах тоног төхөөрөмж судлах, үйлдвэрийн шат дамжлага, үйл ажиллагаатай танилцаж, хамтран ажиллах талаар тохиолцоонд хүрсэн. (Гадаад томилолтын зардал 16,272.0 мянган төгрөг)

Дотоодод 13 удаа томиололтоор ажиллаж орон нутгийн удирдлагуудтай уулзалт танилцуулга хийж, хамтран ажиллах талаар санал солилцож тохиролцоонд хүрсэн. (Дотоод томилолтын зардал 11,513.4 мянган төгрөг).

Компанийн үл хөдлөх хөрөнгийн хэтийн төлөвийг боловсруулах ажлын хүрээнд үл хөдлөх хөрөнгийн ирээдүйн хөгжлийн архитекторын 2 дахь шатны нарийвчилсан эскиз зураг хийлгэхээр БНСУ-ын Studio MOB Architects компанитай 2016 оны 10 дугаар сарын 14-ны өдөр гэрээ байгуулж, мастер төлөвлөгөөг боловсруулж дуусах шатанд явагдаж байна. Энэ ажлын хүрээнд Studio MOB Architects компанийн захирал Dong Suk Han Монголд ирж нөхцөл байдал болон хэтийн төлөвлөгөөтэй, компанийн гүйцэтгэх удирдлага БНСУ-д томилолтоор ажиллаж гэрээт ажлын явцтай тус тус танилцаж, компанийн үйл ажиллагааг

зогсоохгүйгээр оффисын барилга барих ажлын хэсэгчлэн дахин төлөвлөлтийн зургийг хийлгүүлж байна.

Зөвлөх үйлчилгээний Нягтлан бодох бүртгэл хөгжүүлэх сан ТББ-тай гэрээ байгуулж, Компанийн бизнес төлөвлөгөөг компанийн үүсэл хөгжлийн тойм, алсын хараа, эрхэм зорилго, стратеги зорилт, үнэт зүйлс, компанийн үйл ажиллагаа хүрсэн үр дүн, үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа, хүний нөөцийн төлөвлөлт, санхүүгийн тайлангийн шинжилгээ, 2016-2020-2025 оны санхүүгийн таамаглал, 2016-2025 оны санхүүгийн байдал, төлөвлөсөн харьцааны үзүүлэлт зэрэг бүтэцтэйгээр боловсруулж дуусгасан.

Компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр

Компанийн барилга байгууламж, тоног төхөөрөмжид дараах их засваруудын ажил хийж, хөрөнгийн өртгийг 75,218.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн юм. Үүнд:

- МА-II барилгын 2 дугаар давхрын баруун жигүүрийн модон цонхнуудыг вакум цонхоор солих их засварын ажлыг 2016 оны 6 дугаар сард гүйцэтгэгч Сизовконстракшн ХХК-иар 34,200.0 мянган төгрөгийн зардлаар хийлгэсэн;
- МА-III барилгын халаалтын ерөнхий шугам, дулаан хуваарилагчийн их засварын ажлыг гүйцэтгэгч Бонажа ХХК-иар 22,318.2 мянган төгрөгийн зардлаар хийлгэсэн;
- U-I барилгын хойт тал, МА-III барилгын баруун ба урд талын зам талбайн их засварын ажлыг гүйцэтгэгч Сизовконстракшн ХХК-иар 18,700.0 мянган төгрөгийн зардлаар хийлгэсэн;
- Дээрх их засварын ажлуудын тус тусын төсөвт зардлын үнийн дүнгийн 5 хувийг засварын ажлын чанарын баталгааны барьцаа болгон авч үлдэж, 3 жилийн чанарын баталгаа гаргуулсан;

Компанийн барилга байгууламжид 199,021.2 мянган төгрөгийн урсгал засварын ажил хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- МА-II барилгын 1-4 дүгээр давхрын ариун цэврийн өрөөнүүдийн засварын ажлыг 89,651.0 мянган төгрөгийн зардлаар;

-
- МА-III барилга (Анкор төв)-ын фасадын засварын ажлыг 24,000.0 мянган төгрөгийн зардлаар;
 - Автомашины гараашийн фасадын засвар, усны хаялга шинээр хийх ажлыг 17,180.3 мянган төгрөгийн зардлаар;
 - Анкор төвийн барилгын гол танхим, цайны өрөө, кабины хаалга болон цахилгааны засварыг 11,595.0 мянган төгрөгийн зардлаар тус тус гүйцэтгэсэн.

Компанийн цахилгаан эрчим хүчний найдвартай ажиллагааг хангах үүднээс 6 кВ хуваарилах байгууламжийн засвар үйлчилгээ, ХИД-А оруулгын ачаалал таслагчийг шинэчлэх, 0.4 кВ-ын 3 тарифт тоолууруудыг баталгаажуулах, 6/0.4 кВ дэд өртөөний халаалтын систем, гэрэлтүүлэгийн төхөөрөмжийг сольж шинэчлэх, оффисийн гэрэлтүүлэгийн төхөөрөмж, автомашины гараашийн доторх гэрэлтүүлгийг засварлах зэрэг цахилгааны сүлжээ тоног төхөөрөмжид 9,097.4 мянган төгрөгийн урсгал засварын ажил хийж гүйцэтгэсэн.

Компанийн барилгуудын дулааны хангамж, цэвэр бохир усны системийн хэвийн ажиллагааг хангах чиглэлээр дулааны узелийн хуваарилах байгууламж, шугам хоолой, тоноглолыг солих, МА-I, МА-II, МА-III барилгын халаалтын систем, барилгуудын гаднах худгуудыг угаах, МА-II барилгын 1 дүгээр давхрын халаалтын босоо шугам солих, дулааны халаалтын болон цэвэр усны тоолууруудын дагалдах хэрэгсэл солих, тэдгээрийг баталгаажуулах зэрэг сантехникийн системд 14,199,5 мянган төгрөгийн урсгал засварын ажил хийж гүйцэтгэсэн.

Тахько компанийн оффисын бүх өрөө, тасалгааны засварыг 5,578.1 мянган төгрөгийн, оффисын коридорын 2 дугаар давхрын шат хүртлэх засварыг 10,158.6 мянган төгрөгийн, шинээр өрөө гаргах шилэн ханыг 5,370.7 мянган төгрөгийн, МА-I, МА-II, МА-III, U-I барилгуудын дээвэр, ариун цэврийн өрөөний нэмэлт хана, гаднах хаалга, кондешнийн урсгал засварын ажлуудыг 5,060.9 мянган төгрөгийн зардлаар тус тус гүйцэтгүүлж, нийт барилгын урсгал засварт 31,035.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Цаашид ашиглах боломжгүй болсон 2,262.2 мянган төгрөгийн үнэ бүхий барилга, цахилгаан, сантехникийн засварын багаж, хэрэгсэлийг акталж, данснаас хассан.

Цахилгаан эрчим хүчний гадаад, дотоод тооцооны нийт 50 гаруй тоолуурын заалтаар цахилгаан эрчим хүчний хэрэглээний тооцоог тогтмол хийж, 314,212.3 мянган төгрөгийн цахилгаан эрчим хүчний үнийг хэрэглэгчдэд хувиарлан төлүүлжээ. Цахилгааны тоолуурын зөрүү 34,698.0, тарифийн зөрүү 10,445.6, үйлчилгээний үнэ 17,126.4, дулааны төлбөрт 48,046.3, үйлчилгээний төлбөрт 744.6, цэвэр бохир усны төлбөрт 21,243.4, усны үйлчилгээний төлбөрт 721.9, телефон ярианы төлбөрт 983.7, бусад төлбөрт 2,021.3 мянган төгрөгийг хэрэглэгчид хуваарилан төлүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн өөрчлөлт, элэгдэл хорогдлын шимтгэл, сэлбэг, аж ахуй, барилга, хангамж, шатах тослох материал, кассын тооцоонд хяналт тавьж, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг бүрэн хийлгэж, тайлан бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж ажилласанаар ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй, бэлэн мөнгөний зарцуулалт, түүнд тавих хяналт сайжирч, хэвшсэн болно.

Компанийн санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын, хувь хүний орлогын, үл хөдлөх эд хөрөнгийн, авто тээвэр өөрөө явах хэрэгслийн, нэмэгдсэн өртгийн албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог тогтоосон хугацаанд нь гаргаж, хуульд заасан хугацаанд харилцдаг санхүү, татвар, нийгмийн даатгалын байгууллагад тушааж, тайлангийн хугацаанд улсын төсөвт 84,989.0 мянган төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, 173,074.5 мянган төгрөг (үүнээс 118,919.9 нь компаниас, 54,154.5 нь даатгуулагчаас)-ийн нийгмийн даатгалын шимтгэл, 114,922.5 мянган төгрөг(ажиллагсадаас суутгасан 97,992.1, ажил үүрэг гүйцэтгэгчээс суутгасан 4,078.6, ногдол ашгаас суутгасан 12,851.8 мянган төгрөг)-ийн хувь хүний орлогын албан татвар, 12,557.6 мянган төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн болон авто тээврийн болон өөрөө явагч тээврийн хэрэгсэлийн албан татвар, 272,412.9 мянган төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар төлж, улсын төсөвт төлөх төлбөрийн 98.4 хувийг тайлангийн жилд барагдуулсан байна.

Анкор төв үйл ажиллагааны чиглэлийн дагуу хурал, семинар, уулзалт 27, хүлээн авалт 6, шагнал гардуулах ёслол 7, үзэсгэлэн худалдаа 1, урлаг, соёлын тоглолт 4, шинэ жилийн арга хэмжээ 3, нийт 48 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 156 цагийн үйлчилгээ үзүүлснээс 34 удаа 101 цагийн үйлчилгээг үнэ төлбөртэй зохион байгуулж, (НӨАТ-гүй дүнгээр) 17,421.2 мянган төгрөгийн орлоготой ажилласан.

Компани 2016 онд 3,334,205.9 мянган төгрөгийн орлоготой, 2,755.803.0 мянган төгрөгийн зарлагатай, 507,749.6 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллаж, 2015 оны гүйцэтгэлтэй харьцуулахад компанийн орлого 246,415.9 мянган төгрөг буюу 8.0 хувиар, зардал 923,533.3 мянган төгрөг буюу 50.4 хувиар тус тус нэмэгдэж, хуримтлагдсан ашиг 3,169,027.1 мянган төгрөг болж 13.4 хувиар өссөн байна.

2016 онд компани 3,201,205.2 мянган төгрөгийн орлого олохоор төлөвлөж, 3,334,205.9 мянган төгрөгийн орлого олж, төлөвлөгөөг 104 хувиар биелүүлсэн.

Ажлын байр, ажиллах нөхцлийг хангах чиглэлээр

Ажиллагсадын ажлын байр, ажиллах нөхцлийг хангах зорилгоор 30,979.1 мянган төгрөгийн оффисын тавилга, эд хогшил, 17,917.0 мянган төгрөгийн компьютер, принтер, оффисын бусад хэрэгсэл, 5,000.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө, 167,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл болон оффисын барилгын гаднах зам талбайн ашиглалтыг сайжруулахад шаардлагатай 30,031.8 мянган төгрөгийн төхөөрөмж, 1,638.5 мянган төгрөгийн бусад хөрөнгө худалдан авч бэлтгэсэн.

Оффисын зай талбайг ашиглан өөрчлөлт засвар хийж, оффисын төхөөрөмж, эд хогшил бүхий 4 хүний ажлын байр бий болгож тохижуулсан.

Албан ажлын хэрэгцээнд 18,178 мянган төгрөг (шатахуун 12,403.2, бэлэн бүтээгдэхүүн 1,269.9, хангамжийн материал 4,504.9 мянган төгрөг)-ийн хангамжийн материалыг бэлтгэн нийлүүлж хангалт хийсэн.

Цаашид ашиглах боломжгүй болсон 20,163.0 мянган төгрөгийн өртөг бүхий бараа материал, 3,618.3 мянган төгрөгийн өртөг бүхий хангамжийн материалыг акталж, данс бүртгэлээс хасч, холбогдох зардлын дансанд бүртгэсэн.

Оффисын ажилтнуудын компьютерыг шинэчилж, серверт мэдээлэл өгөгдөл хадгалах төхөөрөмж, Анкор төвд нэврэх систем шинээр суурилуулж, автомашины гарааш түүний гадна орчны хяналтын камерыг сольж шинэчилсэн, компанийн компьютерын болон хяналтын дотоод сүлжээний хэвийн ажиллагааг хангах

тохируулга, засвар, үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж хэвийн ажиллагааг хангаж ажилласан.

Ажлын байрны аюулгүй ажиллагааг хангах, ажлын байрны нөхцөлийг сайжруулах зорилгоор цахилгаан, сантехникийн засварчдын өрөө, дулааны узелийг засварлаж, эдэлгээний хугацаа дууссан 5,126.8 мянган төгрөгийн хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийг акталж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор 6,548.3 мянган төгрөгийн ажлын хувцас, хэрэглэл авч бэлтгэсэн.

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ҮЗҮҮЛЭЛТ

(2016 оны 13 дугаар сарын 31-ний байдлаар)

(төгрөгөөр)

Балансын зүйл	Үлдэгдэл		Балансын зүйл	Үлдэгдэл	
	Эхний	Эцсийн		Эхний	Эцсийн
А. Хөрөнгө	х	Х	Б. Өр төлбөр эзэмшигчийн өмч	х	х
I. Эргэлтийн хөрөнгийн дүн	2,033,204,309.15	2,592,367,512.50	I. Өр төлбөрийн дүн	60,413,808.20	106,415,736.00
Мөнгөн хөрөнгө	1,614,063,389.69	1,946,795,163.79	Богино хугацаатай өр төлбөр	60,413,808.20	106,415,736.00
Богино хугацаатай хөрөнгө оруулалт			Урт хугацаатай өр төлбөр		
Авлага	347,931,375.81	369,915,520.22	Үүнээс банкны хугацаа хэтэрсэн өр		
Бусад санхүүгийн хөрөнгө		1,680,000.00			
Бараа, материал	66,634,649.85	46,494,712.49	II. Өмчийн дүн		
Үндсэн ба туслах материал			Төрийн		
Урьдчилж төлсөн тооцоо	4,574,893.80	227,482,116.00	Хувийн		
Бусад			III. Хувьцааны дүн	199,917,144.00	199,917,144.00
II. Биет хөрөнгийн дүн	11,942,652,441.49	11,851,733,611.83	Энгийн хувьцааны тоо, ширхэг	1,189,983	1,189,983
Барилга байгууламж	12,573,428,035.06	12,648,646,313.25	Нэрлэсэн үнэ	168.00	168.00
Газар			Давуу эрхтэй хувьцааны тоо, ширхэг		
Машин тоног төхөөрөмж	116,497,870.46	146,150,060.46	Нэрлэсэн үнэ	168.00	168.00
Тавилга, эд хогшил	201,849,845.93	247,459,313.07	Халаасны хувьцааны дүн		
Тээврийн хэрэгсэл	261,063,687.00	353,063,687.00			
Хуримтлагдсан элэгдэл	1,210,276,996.96	1,543,585,761.95	IV. Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	11,011,787,475.05	11,011,787,475.05
III. Биет бус хөрөнгийн дүн	3,402,461.69	6,764,427.37	V. Хуримтлагдсан ашиг	2,795,051,705.08	3,169,027,116.65
IV. Урт хугацаатай хөрөнгө оруулалт	88,000,920.00	33,811,920.00	Үүнээс: Тайлант үеийн ашиг	1,127,034,129.34	507,749,615.64
Нийт хөрөнгийн дүн	14,067,170,132.33	14,487,147,471.70	VI. Эзэмшигчийн өмчийн дүн	14,006,756,324.13	14,380,731,735.70
			VII. Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	14,067,170,132.33	14,487,147,471.70

Эдийн засгийн үзүүлэлт

(Мянган төгрөгөөр)

Үзүүлэлт		2013 он	2014 он	2015 он	2016 он
I	Нийт орлого	1,364,520.0	1,977,408.0	3,087,790.0	3,334,205.9
A	Үйл ажиллагааны орлого (цэвэр борлуулалт)	1,290,847.3	1,880,382.1	3,011,420.2	3,081,346.8
B	Үйл ажиллагааны бус орлого	73,672.7	97,025.9	76,369.8	252,859.1
II	Нийт зардал	1,050,412.0	1,536,411.0	1,832,249.7	2,755,803.0
A	Борлуулсан барааны өртөг	235,862.4	4,897.9	373,379.4	1,060,350.5
B	Ерөнхий ба удирдлагын зардал	704,641.5	1,059,083.5	1,433,752.9	1,431,079.8
B	Үйл ажиллагааны бус зардал	59,908.1	472,429.6	25,117.5	264,372.8
III	Татвар төлөхийн өмнөх ашиг	314,108.0	440,996.9	1,255,540.2	578,402.8
	Орлогын албан татвар	32,560.7	56,758.0	128,506.3	70,653.2
	Татварын дараах ашиг	281,547.3	384,238.9	1,127,033.9	507,749.6

Нэгж хувьцаанд хуваарилсан ногдол ашиг (төгрөгөөр)

1992	1993	1994	1995	1998-99	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
8.55	2.41	5.48	5.48	28.60	16.25	18.12	36.00	45.00	56.00	56.00	56.00	56.00	65.00	82.00	108.00	108.00

Үнэт цаасны зах зээлийн мэдээлэл

Хувьцааны арилжааны дундаж ханш(төгрөг)	7,324.10	10,055.60	11,628.83	20,505.64
Хувьцааны дансны үнэ (төгрөгөөр)	1,620.55	1,901.82	11,770.55	12,214.01
Хувьцааны хаалтын ханш (жилийн эцсийн)	10,630	11,000	16,990	21,840
Хувьцаа эзэмшигчдийн тоо	623	624	623	623
Хувьцааны төвлөрлийн хувь	83.93	83.93	83.93	83.93

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.ЭНХНАСАН

ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
ДАРГА

Ц.ДОРЖГОТОВ

